



## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
4.1 Залруулсан алдаа .....	12
4.4 Зөвлөмж .....	13
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 23 № 12  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүйсийн говь-цэцэг нуурын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүйсийн говь-цэцэг нуурын сав газрын захиргааны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020659

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,892,100.0</b>	<b>3,726,300.0</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.0	00.0
35	БАРАА МАТЕРИАЛ	4,892,100.0	3,726,300.0
354	Хангамжийн материал	4,892,100.0	3,726,300.0
35410	Бичиг хэргийн материал	543,100.0	1,732,000.0
35420	Аж ахуйн материал	3,974,000.0	24,300.0
35430	Сэлбэг хэрэгсэл	240,000.0	00.0
35440	Түлш, шатах тослох материал	135,000.0	1,970,000.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,833,375.2</b>	<b>10,984,788.7</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.0	00.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,833,375.2	10,984,788.7
391	Газар	00.0	00.0
392	Биет хөрөнгө	8,833,375.2	10,984,788.7
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,157,500.0	15,059,500.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,111,291.6	-13,316,458.4
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,377,310.0	8,968,000.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,590,143.2	-1,964,252.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,160,798.8	2,238,000.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,160,798.8	00.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=+II</b>	<b>13,725,475.2</b>	<b>14,711,088.7</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>13,725,475.2</b>	<b>14,711,088.7</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	13,725,475.2	14,711,088.7
512	Хуримтлагдсан үр дүн	13,725,475.2	14,711,088.7
51210	Өмнөх үеийн үр дүн	13,725,475.2	13,725,475.2
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	985,613.5
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>13,725,475.2</b>	<b>14,711,088.7</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	133,244,114.0	137,467,286.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,959,500.0	9,434,846.9
120	Нийтлэг татварын бус орлого	1,959,500.0	9,434,846.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,959,500.0	9,434,846.9
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,959,500.0	9,434,846.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	131,284,614.0	128,032,440.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	112,775,700.0	110,544,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	112,775,700.0	110,544,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,508,914.0	17,487,640.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,508,914.0	12,410,800.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.0	5,076,840.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	138,434,405.6	136,481,673.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,434,405.6	136,481,673.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,131,435.5	136,259,065.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,341,340.9	63,317,863.0
210101	Үндсэн цалин	48,915,240.9	53,692,827.0
210102	Нэмэгдэл	10,505,700.0	5,994,336.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,920,400.0	3,630,700.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,330,945.3	8,459,220.8
210201	Тэтгэврийн даатгал	5,807,790.9	5,956,854.1
210202	Тэтгэмжийн даатгал	633,500.0	602,515.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	501,409.2	506,546.9
210204	Ажилгүйдлийн даатгал	121,045.3	126,736.9
210205	Эрүүл мэндийн даатгал	1,267,200.0	1,266,567.6
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.0	00.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,829,268.0	20,875,500.0
210301	Гэрэл, цахилгаан	96,200.0	00.0
210302	Түлш, халаалт	115,600.0	00.0
210303	Цэвэр, бохир ус	337,400.0	00.0
210304	Байрны түрээс	19,280,068.0	20,875,500.0
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.0	00.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,879,885.7	8,678,948.7
210401	Бичиг хэрэг	2,119,500.0	669,500.0
210402	Тээвэр, шатахуун	4,133,200.0	5,613,690.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	752,649.7	1,551,158.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	874,536.0	1,376,800.0
2105	Нормативт зардал	00.0	1,425,500.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.0	1,425,500.0
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	1,336,800.0	1,794,800.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,336,800.0	00.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.0	1,464,800.0
210604	Урсгал засвар	00.0	330,000.0
2107	Томилот, зочны зардал	3,261,000.0	5,296,000.0
210702	Дотоод албан томилот	3,261,000.0	5,296,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,413,076.1	9,419,600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,879,276.1	8,910,200.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	199,500.0	143,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,300.0	53,400.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	70,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.0	242,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,739,119.6	16,991,633.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,059,228.0	9,176,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,679,891.6	7,283,433.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,302,970.1	222,607.5
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,302,970.1	222,607.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,302,970.1	222,607.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,190,291.6	985,613.5
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.0	00.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.0	00.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,190,291.6	985,613.5

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>131,284,614.0</b>	<b>128,032,440.0</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>131,284,614.0</b>	<b>128,032,440.0</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	112,775,700.0	110,544,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	112,775,700.0	110,544,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,508,914.0	17,487,640.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,508,914.0	12,410,800.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.0	5,076,840.0
131106	Төсвийн урамшуулал	00.0	00.0
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>131,284,614.0</b>	<b>128,032,440.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>131,284,614.0</b>	<b>128,032,440.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>129,981,643.9</b>	<b>127,809,832.5</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,341,340.9	63,317,863.0
210101	Үндсэн цалин	48,915,240.9	50,498,822.3
210102	Нэмэгдэл	10,505,700.0	9,268,347.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,920,400.0	3,550,693.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,330,945.3	8,459,220.8
210201	Тэтгэврийн даатгал	5,807,790.9	5,956,854.1
210202	Тэтгэмжийн даатгал	633,500.0	602,515.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	501,409.2	506,546.9
210204	Ажилгүйдлийн даатгал	121,045.3	126,736.9
210205	Эрүүл мэндийн даатгал	1,267,200.0	1,266,567.6
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.0	00.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,829,268.0	20,875,500.0
210301	Гэрэл, цахилгаан	96,200.0	70,700.0
210302	Түлш, халаалт	115,600.0	00.0
210303	Цэвэр, бохир ус	337,400.0	47,400.0
210304	Байрны түрээс	19,280,068.0	20,757,400.0
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.0	00.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,211,285.7	8,544,348.7
210401	Бичиг хэрэг	281,000.0	338,800.0
210402	Тээвэр, шатахуун	3,835,000.0	6,598,690.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,472,749.7	843,058.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	622,536.0	763,800.0
2105	Нормативт зардал	285,100.0	285,100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	285,100.0	285,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,515,000.0	178,200.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,336,800.0	00.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.0	178,200.0
210604	Урсгал засвар	00.0	00.0
2107	Томиллолт, зочны зардал	3,261,000.0	5,296,000.0
210701	Гадаад албан томиллолт	00.0	00.0
210702	Дотоод албан томиллолт	3,261,000.0	5,296,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,413,076.1	9,419,600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,879,276.1	8,910,200.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	199,500.0	143,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,300.0	53,400.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	70,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.0	242,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,794,628.0	11,434,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,794,628.0	11,434,000.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,302,970.1</b>	<b>222,607.5</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,302,970.1	222,607.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,302,970.1	222,607.5
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.0</b>	<b>00.0</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.0</b>	<b>00.0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	00.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	00.0

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00	00	18,915,767	00	18,915,766.75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00	00	00	00	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00	00	18,915,767	00	18,915,766.75
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00	00	00	00	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00	00	00	00	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00	00	00	00	-
C07	Тайлант үеийн үр дүн	00	00	-5,190,292	00	(5,190,291.56)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00	00	13,725,475	00	13,725,475.19
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00	00	13,725,475	00	13,725,475.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00	00	00	00	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00	00	13,725,475	00	13,725,475.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00	00	00	00	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00	00	00	00	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00	00	00	00	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00	00	00	00	-
D08	Тайлант үеийн үр дүн	00	00	985,614	00	985,613.52
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00	00	14,711,089	00	14,711,088.71

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	110,544,800.00	110,322,192.47
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	110,544,800.00	110,322,192.47
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	110,544,800.00	110,322,192.47
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	63,359,700.00	63,317,862.99
210101	Үндсэн цалин	54,635,500.00	50,498,822.28
210102	Нэмэгдэл	4,803,800.00	9,268,347.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,920,400.00	3,550,693.07
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,553,600.00	8,459,220.78
210201	Тэтгэврийн даатгал	6,019,200.00	5,956,854.11
210202	Тэтгэмжийн даатгал	633,600.00	602,515.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	506,900.00	506,546.90
210204	Ажилгүйдлийн даатгал	126,700.00	126,736.89
210205	Эрүүл мэндийн даатгал	1,267,200.00	1,266,567.58
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,924,800.00	20,875,500.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	70,700.00
210302	Түлш, халаалт	00.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	47,400.00
210304	Байрны түрээс	20,924,800.00	20,757,400.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,076,200.00	5,056,708.70
210401	Бичиг хэрэг	238,800.00	238,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.00	3,211,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	860,300.00	843,058.70
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	763,800.00	763,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
2105	<b>Нормативт зардал</b>	285,100.00	285,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	285,100.00	285,100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	178,200.00	178,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	178,200.00
210604	Урсгал засвар	00.00	00.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,738,000.00	2,730,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,738,000.00	2,730,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,429,200.00	9,419,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	8,910,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,500.00	143,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,500.00	53,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,000.00	70,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00	242,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	110,037,907.99
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	110,037,907.99
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	110,037,907.99

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	17,487,640.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	17,487,640.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	17,487,640.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,836,840.0
210401	Бичиг хэрэг		100,000.0
210402	Тээвэр, шатахуун		3,387,640.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		349,200.0
2107	Томилолт, зочны зардал	-	2,566,000.0
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		2,566,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,084,800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,084,800.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>17,487,640.0</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	17,487,640.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	12,410,800.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,076,840.0
131106	Төсвийн урамшуулал	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 234 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сав газрын усны нөөцийн нэгдсэн төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичгүүдийн биелэлтийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 133.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 2.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 137.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл өндөр гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14.6 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна. Авлага дансны эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3.7 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр буурсан нь түлш, шатах тослох материал зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 14.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 15.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 3.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10.9 сая төгрөг болж 2.1 сая төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 611 дүгээр тогтоолын үндэслэн 21.9 сая төгрөгийн хугацаа дууссан хөрөнгийг үнэ тогтоон акталж орлого авсан, үнэ төлбөргүй 9.4 сая төгрөгийн орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14.7 сая төгрөг болж 0.99 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 112.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 1.5 сая төгрөгөөр бууруулж, 110.5 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 110.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 110.5 сая төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 17.5 сая төгрөг, нийт 128.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 127.8 сая төгрөгийг зарцуулж 0.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 127.8 сая төгрөг буюу 99.8 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар 17.5 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлогод хуваарилсан хөрөнгөд 12.4 сая төгрөгийг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод 5.0 сая төгрөгийг тайлагнажээ.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос хэмжилт судалгааны ажлын зардал 1.2 сая төгрөг, усны өдрийн таниулах арга хэмжээнд 2.5 сая төгрөг, усны тооллого, худаг паспортжуулах ажлын хүрээнд 5.0 сая төгрөг, хамгаалалтай бүсийн давхцалтай газар хуулийн зөвлөгөө авах ажилд 0.8 сая төгрөг, сүтэй хайрхан ойр орчмын хог хаягдал цэвэрлэх, булаг шандын эх хамгаалах ажилд 1.0 сая төгрөг, хяналтын зардалд 0.1 сая төгрөг, ИТХ төлөөлөгчдөд үйл ажиллагааны тайлан тавих бусад зардалд 6.6 сая төгрөгийн тус тус зарцуулжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 144 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 144 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт орлого олж үйл ажиллагаанд зарцуулсан эсэх
2. Ашиг сонирхол болон хамаарал үүсэхүйц этгээдэд бэлэн мөнгө болон эд материалаар санхүүжүүлсэн эсэхийг давтан үзэх, мөн гадаадын тусламж, хандивлагч байгууллагаас төсөл бичих санхүүжилт хүсэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд нийцүүлсэн эсэхийг үзэх шаардлагатай гэж үзлээ.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

#### 4.2 Төлбөрийн акт

Тус байгууллагын нягтлан бодогч нь гэрээт ажилтнаар ажилладаг бөгөөд дээд байгууллагын баталсан цалингийн сүлжээнээс дээгүүр цалинжиж 0.4 сая төгрөгийн цалинг илүү тооцож авсан нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/158 дугаар тушаалын 21 дүгээр хавсралт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар

зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тус байгууллага нь 29 ширхэг 0.7 сая төгрөгийн үнэ бүхий принтерийн хорыг хүлээж аваагүй боловч орлого авч зарлага гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Хамаарал болохуйц этгээдээс 3.6 сая төгрөгийн хандив авч үйл ажиллагаандаа зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5.1-т "Хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх- тохиолдолд хандив тусламж авахыг хориглоно" гэсэн нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Сумдын ИТХ-ын төлөөлөгч нарт шатахууны зардал 2.4 сая төгрөг өгсөн нь ашиг сонирхол үүсэхүйц нөхцөл байдал үүсгэсэн нь Захиргааны ерөнхий хууль нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлан, Татварын тодорхойлолт 1.3 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр", нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдсөнгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргаа	6	2.4			2	1.1	4	1.3		
5	Дүн	6	2.4			2	1.1	4	1.3		